



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/243

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1-ийн "а", Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 45 дугаар тогтоолоор батлагдсан "Коронавируст халдвар (ковид-19)-ын тархалтын түвшинг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам"-ын хэрэгжилтийг хангах, иргэдийн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зогсоох зорилгоор "Хэнтий аймгийн төв Чингис хотыг бүсчлэн хаах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж хяналтын 11 постод энэ оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл 17 хоногийн хугацаанд ажиллах 22 алба хаагчийн хоол, автомашины шатах тослох материал болон бичиг хэргийн зардлыг хавсралтаар тус тус баталсугай.

2. Урьдчилан сэргийлэх, халдварын тархалтын түвшинг тогтооход шаардагдах 12238,500 (арван хоёр сая хоёр зуун гучин найман мянга таван зуу) төгрөгийг аймгийн Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хянагч тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011530

05 Аймгийн Засаг даргын 2021 оны  
... дугаар сарын 13 өдрийн ... А/243  
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тсоцоо

| Байгууллагын нэр          | ЗАРДЛЫН НЭР ТӨРӨЛ |                      |                  |                 | Дүн               |
|---------------------------|-------------------|----------------------|------------------|-----------------|-------------------|
|                           | Шатахууны зардал  | Бичиг хэргийн зардал | Хоолны зардал    | Холбооны зардал |                   |
| Цагдаагийн газар          | 2,898,500         |                      | 7,480,000        | 150,000         | 10,528,500        |
| Онцгой байдлын газар      |                   | 495,000              |                  | 215,000         | 710,000           |
| Мэргэжлийн хяналтын газар |                   | 1,000,000            |                  |                 | 1,000,000         |
| <b>ДҮН</b>                | <b>2,898,500</b>  | <b>1,495,000</b>     | <b>7,480,000</b> | <b>365,000</b>  | <b>12,238,500</b> |